МонголФарм
НАСАН ТУРШИЙН ЭРҮҮЛ АМЬДРАЛ




# Дэлхийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдөр

## Эмийн аюулгүй байдлын өдөр

2024 он

World Patient Safety Day 17 September

# Агуулга

- Дэлхийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдөр
- Эмийн аюулгүй байдал
- Эмийг аюулгүй хэрэглэх 5 алхам
- Эмийн аюулгүй байдлын өдрийг тохиолдуулан хийх ажлууд
- Ижил төстэй эмнүүдийг ангилах хадгалах журам
- Жагсаалтууд гаргах
- Төлөвлөгөө , биелэлт , тайлан



# Дэлхийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдөр 9-р сарын 17

- Дэлхий даяар үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах болон таагүй тохиолдлыг бууруулах үйл ажиллагааг сурталчлах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор 2019 оноос хойш үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын өдрийг тэмдэглэж байна.
- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-аас Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдрийн арга хэмжээг
- 2021 оны 9 дүгээр сарын 17-нд“Эх, нярайн тусламж, үйлчилгээний аюулгүй байдал”
- 2022 оны 9 дүгээр сарын 17-нд “ Эмийн аюулгүй байдлын өдөр”



World Patient Safety Day 17 September

# Эмийн аюулгүй байдлын өдөр

- Эмийг аюулгүй хэрэглэх 5 алхам гэдэг нь үйлчлүүлэгч эсвэл түүний гэр бүлийнхэн, асран хамгаалагчийн оролцоотойгоор эмийн хэрэглээтэй холбоотой хор уршиг үүсэх эрсдэлийг бууруулахад чиглэсэн түлхүүр зарчмууд юм. Алхам тус бүр нь 5 чухал асуултаас бүрдэнэ. Зарим асуултад үйлчлүүлэгч бие даан хариулах боломжтой бол заримыг нь ойлгож, зөв хариулахын тулд эмнэлгийн мэргэжилтний тусламж шаардлагатай.
- Үйлчлүүлэгчийн оролцоог тусгасан энэхүү зөвлөмжийг ДЭМБ-ын зүгээс "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн 3 дугаар аяны нэг хэсэг болгон: Эмийн зохистой хэрэглээ сэдвийн хүрээнд" боловсруулан гаргасан.
- Энэхүү зөвлөмж нь үйлчлүүлэгчийг эрүүл мэндээ хамгаалахад илүү идэвхтэйгээр татан оролцуулах, эмийн талаарх мэдээлэлд тэдний анхаарлыг хандуулах, эмийн зохистой хэрэглээний талаар эмнэлгийн мэргэжилтнүүдтэй нээлттэй харилцах боломжоор хангахад чиглэсэн юм.
- Зөвлөмжийг үйлчлүүлэгч, тэдний гэр бүл, асран хамгаалагч нарт зориулан боловсруулсан ба хэрэгжүүлэхэд эмнэлгийн мэргэжилтнүүдийн дэмжлэг, хамтын ажиллагаа шаардлагатай.



World Patient Safety Day 17 September

# Эмийг аюулгүй хэрэглэх 5 алхам




- Эмч ,сувилагч , эмзүйч, эмнэлгийн ажилтнууд үзүүлэхдээ
- Эмийн сангаар үйлчлүүлэхдээ
- Өөр эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхэдээ
- Шилжин эмчлүүлэхдээ
- Гэрийн болон өдрийн эмчилгээ авахдаа



# 1.Эм ууж эхлэх үе

- Энэ эмийн нэр нь юу вэ, ямар үйлчилгээтэй вэ?
- Энэ эмийн гаж нөлөө нь юу вэ?
- Миний өвчин, эмгэгийг эмчлэх өөр арга бий юу?
- Харшил болон бусад өвчин, эмгэгийнхээ талаар эмчдээ хэлсэн билүү?
- Энэ эмийг яаж хадгалах вэ?






World Patient Safety Day 17 September

# 2.Эм уух үе

- Энэ эмийг хэдэн цагийн зайтай өдөрт хэдэн удаа, нэг удаад хэр хэмжээгээр уух вэ?
- Энэ эмийг яаж уух вэ?
- Энэ эмийг уух үедээ хоол эсвэл уух зүйлтэй холбоотой мэдвэл зохих зүйл байгаа юу?
- Хэрвээ эмээ уухаа мартвал яах ёстой вэ?
- Эмийн гаж нөлөө илэрвэл яах ёстой вэ?






World Patient Safety Day 17 September

# 3.Нэмж эм уух үе

- Надад нэмэлтээр эм уух зайлшгүй шаардлага байгаа юу?
- Одоо ууж байгаа эмийнхээ талаар эмчдээ хэлсэн билүү?
- Энэ эм нь миний ууж байгаа бусад эмтэй зохицох уу?
- Хэрвээ зохицохгүй гэвэл яах ёстой вэ?
- Би олон эмийг нэг дор зөв хэрэглэж чадах болов уу?






# 4.Ууж байгаа эмээ хянах үе

- Ууж байгаа бүх эмийнхээ жагсаалтыг хадгалах шаардлагатай юу?
- Эм тус бүрийг хэр удаан уух ёстой вэ?
- Уух шаардлагагүй болсон эмийг хэрэглэсээр байна уу?
- Ууж байгаа эмийг эмнэлгийн мэргэжилтэн байнга хянаж байна уу?
- Ууж байгаа эмийг эмнэлгийн мэргэжилтэн хэр хугацаанд хянаж байх ёстой вэ?






World Patient Safety Day 17 September

# 5.Ууж байгаа эмээ зогсоох үе

- Эм тус бүрийг хэзээ зогсоох хэрэгтэй вэ?
- Миний ууж байгаа эмнүүдээс шууд зогсоож болохгүй эм байгаа юу?
- Эм дуусвал яах ёстой вэ?
- Эмийн гаж нөлөөнөөс болж эмээ уухаа боливол хэнд мэдэгдэх ёстой вэ?
- Үлдэгдэл эсвэл хугацаа нь дууссан эмийг яах ёстой вэ?






World Patient Safety Day 17 September

# Эмийн аюулгүй байдлын өдрийг тохиолдуулан хийх ажлууд

- Өдөрлөг зохиох (эмийн аюулгүй хэрэглэх 5 алхамаар үйлчлүүлэгч ,тэдний гэр бүл , асран хамгаалагч нарт танилцуулан, асуултанд хариулах замаар үйлчлүүлэгчийн оролцоог дэмжих )
- Ойролцоо өрхийн эмнэлэг , эмнэлгийн байгууллагадаа мэдээлэл түгээх
- Шаргал өнгийн гастук зүүх
- Тайлан бэлдэж өгөх
- Өөрсдийн мэдээллийн сувгуудаар мэдээллийг түгээх



# Ижил төстэй эмнүүдийг жагсаалт гаргах

**Ижил дуудагддаг**

## Ижил төстэй дуудагддаг эмүүд

| Апротинин 10,000 ед/мл 10мл | Атропин 0.1%-1мл |
|---|---|
| Амиодарон 200мг | Амлодипин 10мг |
| Амоксициллин 500мг | Ампициллин 500мг |
| Нифедипин 20мг | Никардипин 25мг/ 10мл |
| Ампициллин 1г | Амприлан 10мг |
| Бромгексин 8мг | Бромокриптин 2.5мг |
| Клодроны хүчил 400мг | Клопидогрел 75мг |
| Клопидогрел 75мг | Клотримазол 100мг |
| Карболен 250мг | Карбоплатин 450мг |
| Цефотаксим 1г | Цефтриаксон 1г |
| Дексаметазон | Декстрометорпан |

**Ижил найрлагатай**

## ИЖИЛ ТӨСТЭЙ ЭМИЙН МЭДЭЭЛЭЛ

| Эмийн нэр | Найрлага |
|---|---|
| Анаферон | Хүний цэвэршүүлсэн гамма интерфероны антител 0.003г* |
| Анаферон (хүүхэд ) | Хүний цэвэршүүлсэн гамма интерфероны антител 0.003г* |
| Эргоферон | Хүний гамма интерфероны эсрэг цэвэршүүлсэн антител – 0,006г*<br>Гистамины эсрэг цэвэршүүлсэн антител -0,006г*<br>CD4-ын эсрэг цэвэршүүлсэн антител – 0,006г* |


Thank you


MEDICATION WITHOUT HARM
World Health Organization
Аюулгүй эмийн эмчилгээ
ДЭМБ Үйлчлүүлэгчийн Аюулгүй Байдлын Дэлхийн Аян


Хамтдаа үлгэрлэе
Хандлагаа өөрчилье
харилцан
хүндэтгэе
Хайраа хайрлая